

2.7. ЭРТНИЙ ГРЕКЧҮҮДИЙН ШАШИН ШҮТЛЭГ

Түлхүүр үгс: Грекийн домог, сүсэг бишрэл, Эллада, Гомер, Илиада, Одиссей, Олимп, Зевс, Афин, титан

Товч утга: Эртний Грекчүүдийн шашин шүтлэгийн түүхийг бүхэлд нь Олимпын өмнөх үеийн, Олимпын үеийн, баатарлаг үеийн гэж гурав ангилдаг бөгөөд хоёр дахь нь хамгийн гол үе юм. Эхэн үедээ байгаль-эх шүтлэг, фетиш шүтлэг давамгайлж байсан грекчүүд шашин шүтлэгийнхээ хамгийн оргил үед Олимп уулнаас төрсөн Зевс бурханаар удирдуулсан хязгааргүй олон тэнгэр-бурхадын тухай домог гаргаж өөрсдийн амьдрал үйл явдал бүхнийг ямар нэг тэнгэр-бурханаар бэлгэдэх болжээ. Энэ нь орчин үеийн Өрнийхний шашин шүтлэгт тодорхой байр суурь эзэлдэг.

Эртний Грек гэдэг бол орчин үеийн өрнийн соёл иргэншлийн дээд өвөг гэж тооцогддог. Тэрхүү агуу соёлын нэгэн салшгүй хэсэг нь эртний Грекийн домог шүтлэг билээ.

Эртний грекчүүдийн шашин шүтлэгийн талаар утга зохиолын болон шинжлэх ухааны олон тооны бичгийн эх сурвалжууд бий. Хамгийн гол бичгийн сурвалж нь Гомерын "Илиада", "Одиссей" хэмээх хоёр алдарт домог туульс, мөн Гомерын дууллууд болой. Гомер өөрийн домгууд дахь үйл явцын бодит үнэн гэдэгт өчүүхэн ч эргэлзсэн шинж байдаггүй юм. Харин Гесиод нь грекийн хот-улсын систем, үзэл суртал бүрэлдэж байх үед амьдарч байсан учраас домгийн бурхдын гарал үүслийн асуудлыг илүү хөндсөн байдаг. Грекийн сонгодог утга уянгын шүлгүүд болон Эсхил, Софокл, Еврипид зэрэг грекийн жүжгийн зохиолуудаас эртний грекчүүдийн сүсэг бишрэлийн төсөөлөл, мэдрэмжийг олж харж болох юм. Эртний грекчүүдийн шашин шүтлэгийн талаар Аристофан, Геродот, Полибий, Сицилийн Диодор, Овидий, Вергилий, Гораций, Лукреций Кар, Лукиан, Плутарх, Цицерон, Плотин зэрэг эртний грек, ромын түүхч, зохиолч, сэтгэгчдийн бүтээлээс мэдэж болно. Тэд грекчүүдийн домог шүтлэгийн талаар өөр өөрийн гэсэн тайлбар судалгааг гаргасан байдаг. Мөн эрт үеэс өнөө үеийг хүртэл грекийн домог цуглуулга, домог эмхтгэл, домог тайлбар, домог судлалын ажил өргөн хийгдэж иржээ.

Аливаа ард түмний шашин шүтлэг нь тухайн газар орны онцлог, байгаль цаг уурын нөхцөл байдал, ард түмний аж амьжиргаа, эрхэлдэг аж ахуй зэргээс шалтгаалдаг нь мэдээж. Эртний Грекийн нутаг дэвсгэр нь тэнгис далайгаар

хүрээлэгдсэн хөндий толгодуудаас тогтож байжээ. Хурдан урсгалт гол мөрнүүд нь тал хөндий, ой моднуудаа бүрэн ундлан чийгшүүлж чаддаггүй учраас хуурайвтар газар нутагт тариалан эрхлэхэд тохиромж муутай аж. Иймээс эртний грекчүүд далайн аяллыг голлон эрхэлж гаднаас үр тариа, бараа таваар тээвэрлэн авчрахыг чухалчилдаг байжээ. Гэхдээ загас агнуур болон жимс жимсгэнэ, ялангуяа усан үзмийн тариаланг өргөн эрхэлдэг байна. Эртний грекчүүд ой мод, уул ус, далай тэнгис бүхэн өөр өөрийн сахиусан тэнгэр-бурхантай гэж итгэдэг байж. Байгаль, ургамал, амьтны үйл үзэгдэл бүхэн өөрийн эзэнтэй. Газар тариалангийн бурхан Деметра болон түүний охин Персефон бурхан тэнгэрийн шүтлэг нь эрт үеэс үр жимс газар тариаланг дээдэлж байсны илэрхийлэл юм.

Эртний Грекийг домог шүтлэгээрээ алдартай гэдэг ч эртний Грекчүүдийн шашин шүтлэгийн түүхийн эхэн үе буюу Олимпын өмнөх үед фетиш шүтлэг голлож байжээ. Тэгээд ч эртний грекчүүдийн чулуун пирамидын шүтлэгээс Зевс шүтлэг буюу Олимпын домог шүтлэг үүссэн гэдэг.

Энэхүү эрт балар үеэс хойшхи нэлээд сүүл үе гэж хэлж болох Олимп шүтлэгийн үед ч фетиш шүтлэгийн илэрхийлэл болсон Зевс, Гера, Аполлон, Афина, Паллада, Афродита, Эрот, Геракл бурхадыг хад чулуу, модны хожуул зэргээр бэлгэдсэн байх нь элбэг гэдэг. Хронос хэмээгч тэнгэр-бурханаас айсан Рея эх дагина Зевсийн оронд чулуу өлгийдөн авчирч өгч залгиулсан домог бий. Энэхүү домогт өгүүлэх чулуужсан Зевс бурханд итгэж Дельфах хотын төвд чулуун хөшөө босгон, элдэв хувцас чимэглэл зүүж шүтдэг болжээ. Ер нь Эртний Грекийн соёлд эртний Египетийн нөлөө байсан гэж судлаачид үздэг. Тусгай зориулалт бүхий аврага том барилга байгууламжууд болон гантиг чулуун баримлаар домгийн баатар-тэнгэр бурхадыг бүтээх нь элбэг байжээ.

Грекчүүдийн шүтдэг тэнгэр-бурхан бүхэн өөр өөрийн фетиш бэлгэдэлтэй. Жишээ нь цэргийн бурхад хоёр ирт сүх юмуу найман талт бамбай барьсан байдаг. Мөн зарим хаадын ордны, жишээ нь Кноссын ордны доор хүн-сарлаг амьдардаг гэх мэт домгууд бий. Грекчүүд Аполлоныг чавхдаст лийр хөгжим гартаа барьсан үзэсгэлэнт залуугаар, харин Афродитаг гоо үзэсгэлэн бүрдсэн залуу эмэгтэйн дүрээр төсөөлдөг нь грекийн домог шүтээний хөгжлийн тодорхой үеийг илтгэж байгаа юм.

МЭӨ XIX-XYIII зууны үеэс баян ядуугийн ялгаа мэдэгдэхүйц болсноор оршуулгын зан үйлд зарим өөрчлөлт орсон гэнэ. Египетийн нөлөөгөөр бий болсон чулуун тамгаар хувь хүний эд хогшлыг тамгалан хувьчилж нас эцэслэхэд нь хамт

оршуулдаг болжээ. Тамган дээр эртний грекчүүдийн шүтээн болох далайн хөлөг онгоцны зураг дүрсэлсэн байдаг байна¹. Баян гэр бүлүүдийн булшинд хөшөө дурсгал босгох болжээ. Хаадын булшийг маш гүн, бүр 5 метр хүртлэх гүн, 27 кв.м. өргөн нүхэнд оршуулсан² байдаг ажээ. Грекчүүд хүн нас барахад эхийн хэвлийд байгаа хүүхдийн байрлалаар оршуулдаг байжээ³.

Грекчүүд бүр эрт үед байгалийг, ялангуяа ургамал амьтны ертөнцийг үр төлөөрөө өсгөн үржүүлдэг агуу эх бурхан тэнгэрийг шүтдэг байснаа дараа нь эцэг бурхан тэнгэрийг шүтэх болжээ.

Сүүл үеийн Элладын түүхийг Микений үе ч гэж нэрлэдэг. Энэ үед буюу "мэе III-II дахь мянган жилд бөмбөгөр оройтой, тасалгаат, уурхайн, хайрцагласан, нүхэн булш гэсэн үндсэн таван төрлийн оршуулах ёс байжээ. Хайрцагласан булш нь үнэндээ нүхэн булш юм. ...Ийм булшны төрлүүдийн эд зүйлс нь нэн ядуувтар байдаг. Эртний Микений үеийн өөр нэг чухал дурсгал нь уурхайн булшнууд юм. Бага зэрэг уртавтар тэгш өнцөгт ийм булш нь 3-4 метр гүнд зөөлөн хадыг цоолж хийсэн байдаг. Ийм булшны эд зүйлс нь алт, мөнгө, хүрлээр хийсэн баян тансаг болой. Тэрчлэн булшнаас хув, тэмээн хяруулын өндөг зэрэг гаднаас тээвэрлэн авчирсан зүйлс олдсон юм. Булшнаас олдсон соёлын зүйлсээс нь [харахад] ...удирдагчдын омогт хамааралтай нь тодорхой байна.

Оршуулгын дөрөв дэх төрөл нь толгодын дунд босгосон тасалгаат булш юм. Булшны тасалгаа руу дромос хэмээх нээлттэй хонгилоор явж очно. Тасалгаат булш нь гол төлөв гэр бүлийн бунхан юм. Эд зүйлсийн дотор үйлдвэрлэлийн багаж хэрэгсэл, гэр ахуйн эд юмс, янз бүрийн зүүлт чимэглэл болон бусад зүйлс орно. Иймэрхүү булш зөвхөн Микенээс олдсон гэх төдийгүй эдгээр нь нэр хүндтэй, язгууртан гэр бүлүүдийн шарилын бунхан болно.

Оршуулгын тав дэх төрөл нь сүүл үеийн элладын 14 метр хүртлэх диаметр бүхий бөмбөгөр оройтой булшнууд юм. Энэ нь чулуугаар өрсөн, ойролцоогоор суурьтайгаа адил өндөртэй асар том байгууламж билээ. Уран барилгын үүднээс ийм булшнууд нь тасалгаат булшны дараагийн хөгжлийн үр дүн байсан бөгөөд, мөн л хонгилтой болой. ...Ихэнх хэсэг нь бүр дээр үед тоногдсон байх боловч нарийн байгууламж, хадгалагдаж үлдсэн зарим эд зүйлсээс үзэхэд эдгээр нь "бөмбөгөр оройт

¹ История Древнего мира. Древняя Греция. Минск Харвест. 1998. стр.15

² мөн тэнд. х.62

³ История Древнего мира. Древняя Греция. Минск Харвест. 1998. х.58

булшны хаанчлал" хэмээн хаадын нэрлэснээр хаадын оршуулгын газар болно"¹. Баячууд, хаадуудыг оршуулахдаа тэдний хайртай байсан нохой, морь зэргийг нөгөө ертөнцөд эзэнд нь үйлчлүүлэхээр хамт оршуулах ёс байжээ. Жишээ нь Патроклыг оршуулахад 4 морь, 2 нохойг хамт булшилжээ. Хотын баячуудыг ларнак хэмээх шавар авсанд оршуулдаг байв. Ийм оршуулгын зан үйлд олон хүмүүс оролцдог байсан нь авсны ханан дахь зурагнаас харагдана.

Нэрсийн жагсаалт бүхий шавар самбарт хаад болон сүм дуганы эздийн нэрсийг архивлан жагсаахдаа боолчуудын нэр, гарал нутаг, хүүхдүүдийг нь хамт дансалдаг байжээ. Энд грекийн домгийн аль нэг баатарт зориулан босгосон сүм дуганы тахилд хэчнээн охид хөвгүүдийг өргөснийг тооцсон байна. Тэднийг сүм дуганыг нь хоол хүнсээр хангуулах зориулалттайгаар газарт булдаг байжээ². Нэрсийн жагсаалтад хаадаас гадна зайрангуудын нэр бичээстэй байдаг.

Ер нь хүн нас барсны дараа энэ ертөнцийн амьдрал нь зогсдог ч хойд ертөнцийн амьдрал эхэлдэг гэсэн итгэл үнэмшлийн үүднээс оршуулгын зан үйлийг гүйцэтгэдэг. Аль ч ард түмэн, үндэстэн угсаатны түүхийн бүхий л үед хүмүүсийг нас барахад янз бүрийн оршуулгын зан үйл гүйцэтгэж байсан нь түүх-археологийн олдвороос нотлогддог ажээ. Эндээс шашин шүтлэг хүн төрөлхтөнтэй хамт үүссэн гэж хэлж болно. Нас барагсдыг оршуулахдаа энэ ертөнцөд амьдарч байх үедээ эдэлж хэрэглэж байсан зүйлсийг нь хамт оршуулдаг нь хойд насны амьдралд нь итгэж буйн нотолгоо болно. Энэ итгэл гүнзгий байхын хэрээр хамт оршуулсан эд зүйлс нь олон болж, тэр ч бүү хэл хайртай адгуус амьтан, эхнэр хүүхэд, зарч боолчуудыг нь хүртэл оршуулах ёс ихэнх ард түмний түүхэнд тааралддаг.

Грекчүүдийн шашин шүтлэгийн түүхийн хоёр дахь бөгөөд хамгийн гол үе болох Олимпын үед эцгийн эрхт ёсны үзлийг хамгаалсан шүтээн үүссэн байна. Домгийн бурхадууд янз бүрийн чөтгөр шулам, муу хүчтэй тэмцэлдсэн тухай өгүүлэх болжээ. Олон бурхадаас гол удирдагч нэгэн бурхан Зевсийг илүү шүтэх болсон байна. Бурхадын бүх тэмцэл тулааныг Зевс удирдах болов. Эртний шүтлэгт эх дагинасын үүрэг байр суурь ч өөрчлөгдөж ирэв.

Эмэгтэй хүнийг грекчүүд гоо сайхны үүднээс байгаль эхийн хувилгаан дүр хэмээн дээдэлдэг болжээ. Иймээс Грекийн урлагт эмэгтэйчүүдийг байгалийн эх дүрээр нь дүрслэхийг чухалчилдаг байна. Гэхдээ эх бурхан тэнгэрүүдэд эртний

¹ мөн тэнд. х.65-67

² История Древнего мира. Древняя Греция. Минск Харвест. 1998.. х.80

шашны зан үйлийн тусгай өмсгөлийг өмсгөсөн байдаг нь тэднийг зайран болгон дүрсэлсний илрэл юм. Тэдний биеийг хагас ороосон өмсгөл нь тоо өнгөний хувьд ид шидийн хүчийг илтгэнэ¹.

Энэ үеэс орд өргөөг шүтээний сүм дугануудаар чимэглэх болжээ. Гэхдээ грекийн урлагт шашин, сүсэг бишрэлийн утга агуулга Египет, Вавилоныхоос бага ажээ. Хаад зайрангуудыг барилга байгууламжийн хананд товойлгон дүрсэлж дээдэлсэн байдаг. Гэхдээ ихэнх зайрангууд нь байгалийн эх дагинас юм. Эртний грекийн сүмийн барилгуудаас хамгийн том нь Спарт дахь Орфийн Артемидийн сүм юм. Чулуун суурьтай, өргөөшөө 4.5 метр, уртаашаа 12 метр энэхүү байгууламжийн хананд модоор бурхадыг сийлжээ.

Грекийн домог шүтээний түүхийг фессалийн өмнөх үе, олимпийн өмнөх үе, фессалийн үе, олимпийн үе, сонгодог баатарлаг үе гэж ангилдаг². Эртний Грекийн домог нь мээ III-II дахь мянган жилийн тэртээх түүхэн бодит үйл явдлыг илэрхийлдэг гэдэг. Эгейн сав газрын өнцөг булан бүрд үүссэн хэсэг бусаг домог өгүүлэмжүүд аажмаар нэгдэн өвөрмөц шашны төсөөллийг бий болгожээ. Түүхийн явцад овгууд нэгдэхийн хэрээр газар тариалан, жимс жимсгэнэ эрхлэн хөдөлмөр өрнөж байх үед болон хөдөлмөрийн үр шимийг хүртсэн янз бүрийн баяр ёслолын үед зориулсан, мөн аян дайны, найр хуримын зэрэг дууллууд, магтаалууд гарчээ. Үүнтэй зэрэгцэн бурхад, эх дагинасын тухай, тэд хэрхэн хүмүүсийн болон овог аймгийн хувь заяаг шийдвэрлэж байгаа тухай үлгэр өгүүлэмжүүд үүссэн байна. Тэдгээрийг газраас газарт, үеэс үед дамжуулагчид нь хэсүүчлэн тэнүүчлэгч дуучид (аэд) байсан гэнэ. Улмаар Грек даяар өгүүлэгдэх бурхад, баатруудын тухай домгууд бий болжээ. Ийнхүү алдарт Илиада болон Одиссейн домог үүссэн байна. Эдгээр домгууд нь олон үеийн туршид ам дамжин уламжлагдсаар мээ VI зуун хүрч сая бичгийн хэлбэрийг олжээ. Эрт үеийн домог өгүүлэгч аэдуудын нэг сохор дуучин Гомер эртний грекчүүдийн аман домгийг цуглуулан цэгцэлж өөрийн домгоо бичсэн гэдэг. Иймээс Гомерийг Илиада ба Одиссейн домгийн зохиогч гэнэ. Тэрээр ойролцоогоор мээ XI-VIII зууны үед амьдарч байсан ажээ.

Гомерийн домогт бурхадыг дараахь байдлаар зохион байгуулалтад оруулан домогчилсон байна. Домгийн бурхадаас хамгийн хүчтэй нь аянга цахилгааны бурхан Зевс болой. Түүний дараагийн гэрлийн бурханд Аполлон орно. Аполлоныг "цацраг

¹ мөн тэнд. х.42-44

² Греческая мифология // Мифы народов мира: Энциклопедия. Т.1. М., 1987. Х.321

туяат", "алтан сэлэмт", "мөнгөн нумт" "гэрлээс төрсөн" гэх мэтчилэн нэрлэдэг. Тэрээр мэргэн харваач төдийгүй өвчнийг анагаагч шидтэн гэнэ. Эмч гэсэн утгаар түүнийг Пэон, Асклепий хэмээн нэрлэх нь ч буй. Зевсийн ихэр хөвгүүд болох хоёр Диоскур ч гэрлийн бурхан гэж тооцогддог. Аполлон, Геракл, Гермес гурав нь нарны бурхад юм. Гефестийг Зевсийн дараах аянга цахилгааны бурхан гэдэг. Тэрээр газар дээрхи галыг хариуцаж, төмрийн дархны үйлийг ивээнэ. Грекчүүд ямар нэг баяр ёслол хийж, ам тангараг өргөхдөө огторгуйн бурхан Гедиосын нэрийг дурдалгүй өнгөрдөггүй гэнэ. Посейдон бурхан далайг хариуцах ба түүний зан үйлд морь чухал үүрэгтэй ажээ. Дионис бурхан бол эхэндээ газар тариалан, мал аж ахуйн бурхан байгаад сүүлдээ үр жимс, мөнхийн үржил хөгжлийн бурхан болжээ. Зевсийн эхнэр Гера буюу Диана тэнгэрийн хатан хаан гэнэ. Түүнийг хааны алтан суудлаар бэлгэднэ. Зевсийн ухаалаг зоригт охин тэнгэр Афин нь зоригт дайчдыг хамгаалж, оюун ухааныг тэжээнэ. Илиадад гол байр эзэлдэг Гефест бурхан гар урлал, урлагийг тэтгэдэг. Деметра бурхан бол эд баялгийг бэлгэднэ. Сарны бурхан, айл гэрийн голомт, гэр бүлийн аз жаргал, эр эмийн нандин харилцааг Афродита, Артемида хэмээх охин бурхад хариуцах ба тэднийг алтан ээрүүлээр бэлгэддэг. Грекийн домгийн бурхадын дотор Грекчүүдийн унаган шүтээн бурхадаас гадна далай тэнгис, аян дайны харилцаанд орсон бусад ард түмний шүтээн бурхад ч буй. Жишээ нь, Артемид, Эфес зэрэг бурхад Азиас гаралтай гэж судлаачид үздэг. Бурхадын байр суурь нь гол бурхан Зевсээс хэр алслалтай байгаагаас шалтгаална.

Бурхад нь Олимп уулнаас гарсан гэх ба ийнхүү бурхадыг Олимпэд төвлөрүүлснээр Олимпын шашин гэж нэрлэж болохоор шашны нэгдсэн хэлбэр бий болсон байна. Зевс тэргүүтэй Олимпийн бурхадын ертөнц нь Олимп уулын ойролцоо нутагласан эртний грекчүүд уулын оройгоор хөвөх үүлсийн дээр өдрийн гэрэл гэгээг тусгагч бурхад байгаа хэмээн итгэдэг байснаас домог шүтээн нь үүсчээ. Олимп уулыг бурхадын орон байр гэж үзэж байв. Энэ бол Фессали нутаг дахь шүтээн уул болой. Үүлэн дээр сүндэрлэх цаст орой нь эртний грекчүүдийн хувьд ид шид мэт санагддаг байснаас түүнийг бурханчлан төсөөлж байжээ. Олимпын гол арван хоёр бурхан байдаг: Зевс, түүний ах Посейдон, эгч нар нь болох гэрийн голомт бурхан Гестия, үр жимсний бурхан Деметра, Зевсийн эгч-эхнэр Гера, хүүхдүүд нь болох Афина, Афродита, Аполлон, Гефест, Гермес, Арес, Геба нар болой.

XX зууны эхэн үеийн оросын алдарт домог судлаач Н.А.Кун грекийн домгийн хамгийн гол гэгдэх 50 орчим бурхад, мөн 50 гаруй баатруудтай холбоотой домгуудыг

эмхтгэсэн байх ба хэд хэдэн бүлэг туульсыг судалжээ. Тэрээр Зевс, Аполлон, Афин, Дионис зэрэг гол бурхадын гарал үүсэл, бурхдын үйл ажиллагаа, гарал үүслийн холбоог харуулсан домгуудыг бүлэглэн эмхэтгэжээ. Тэрхүү домогт Зевсийн гарал үүслийг харуулсан хэсгийг авч үзвэл: "Крон өөрийнх нь гарт засаглал үеийн үед байна гэдэгт итгээгүй юм. Тэрээр өөрийнхөө эцэг Ураныг хааш нь хүргэсэн билээ, хөвгүүд нь мөн л түүний эсрэг босч өөрийг нь ч тийш нь хүргэнэ гэж айж байв. Тэгээд Крон эхнэр Рея-даа төрүүлсэн бүх хүүхдүүдээ авчрахыг тушааж хайр найргүй залгиж эхлэв. Хүүхдүүдийнхээ хувь заяаг харсан Рея айн балмагджээ. Гестия, Деметра, Гера, Аида, Посейдон гэдэг таван хүүхдийг нь Крон хэдийнээ залгисан байлаа. Рея сүүлчийн хүүхдээ алдахыг хүссэнгүй. Эцэг эх болох Уран-тэнгэр эцэг, Гея-газар эхийн зөвлөснөөр Крит арал руу зугтан зайлж, тэнд гүн агуйн дотор Зевс хүү нь төржээ"¹. Н.А.Куны тайлбарласнаар Гестия нь тахилгын гал, айлын гал голомтын сахиус болохын зэрэгцээ төр улсыг сахин хамгаалагч охин бурхан юм. Мөн Афин бурханы төрсөн тухай домогт өгүүлэхдээ: "Зевс өөрөө Афин-Паллад охин бурханыг төрүүлсэн. Аянгын агуу бурхан Зевс нь оюун ухааны эх бурхан Метисийг хоёр хүүхэд төрүүлнэ гэж мэдэж байв. Тэр нь Афин охин, ер бусын ухаан хүчит хүү хоёр юм. Хувь заяаны охин бурхад-Мойрууд Зевсэд Метис эх дагинын хүү нь түүнийг суудлаас нь унагаж, түүнээс ертөнцийг удирдах эрхийг нь авна гэдгийг хэлжээ"². Афин бурхан бол хотыг хамгаалагч, шинжлэх ухааныг тэтгэгч бурхан билээ.

Гомерын домогт ертөнцийн эхлэлийг Океан тэнгэр болон Тефида эх дагина гэсэн хос бурхадын дүрээр илэрхийлдэг. Океан бол бүх бурхадын өвөг эцэг, түүнээс ертөнцийн бүх юмс үзэгдэл эх үндсээ авсан. Энэхүү эх үндэс нь дэлхийг бүслэгч цэнгэг уст гол мөрнүүд юм. Тэрээр горхи булаг, худаг усыг тэжээнэ. Океан бурхан мөн газрын гүн рүү нэвтрэн орох чадвартай болой. Грекийн домог үзлээр ертөнц нь тэнгэр, газар, газрын гүн гэсэн гурван хэсгээс бүрдэнэ. Тэнгэрийн од эрхсийг Атлант бурхан сахин хамгаалдаг. Нар бол Гелиос бурхан мөн бөгөөд, харин сар нь Селена эх дагина юм. Селенагийн эгч Эос эх дагина бол үүрийн туяа болой. Газрын гүн дэх ертөнц нь Эреб, Аид, Тартар гурван бурхны эзэмшилд хуваагддаг. Бурхдууд өөр хоорондоо төрлийн холбоотой байна. Жишээ нь, Гипнос бол үхлийн бурхан Танатосын ихэр бурхан, аймшгийн бурхан Фобос нь дайны бурхан Аресын хүү; шороо, ус, агаар нь ах дүү Аид, Посейдон, Зевс гурваар амилдаг гэх мэт.

¹ Н.А.Кун. Легенды и мифы древней Греции. Минск 1989. X.15-16

² мөн тэнд. X.43-44

Олимпийн бурхад нь үзэсгэлэн гоо, гэрэл гэгээ, эр зоригоороо бүхнийг гайхшруулан, хүмүүст хамгийн их ойр байж, хаа сайгүй ноёрхох боловч бүхнийг удирдаж чаддаггүй. Тэд дурлаж, үзэн ядаж, инээж, уйлдаг. Гэрлийн бурхан Аполлон, цэргийн бурхан Арес, худалдаа жуулчлалын бурхан Гермесийг газар бүрд адил байр сууринд шүтдэггүй. Тухайн газар орны амьдрал хувь заяанд хамгийн их нөлөөтэйг эхний байранд тавина. Иймээс газар бүхний дээд шүтээн бурхан нь өөр өөр байдаг. Зевсийн төрлийн бурхадыг илүү дээдлэнэ. Түүнээс гадна бурхан бүхэнд өөр өөрийн ойрын анд нөхөр бурхан бий¹.

Грекийн домогт бурхадыг үл дээдлэгсдийг шүүмжилсэн байна. Бурхан эс шүтэгсдээр тахил өргөх ёс байжээ. Нийгмийн гишүүдийн зүй бус үйлдлийг газар доорхи шүүлтүүрээр оруулах тухай ойлголтыг бий болгожээ. Газар дор үхэгсдийн сүнсний амьдрал явагддаг. Сүнс бүхэн амьд байх үедээ сайн муу үйл хийж байснаасаа хамаараад өөр өөрсдийн шүүлтүүрээр орно. Харон гэгч үхэгсдийн сүнсийг Ахеронт голоор гаталгахад хүмүүсийн ой ухаан алдагддаг. Голын нөгөө эрэгт Цербер гэгч нохой сүнсийг угтан авч Гадес хааны өмнө сөхрүүлнэ. Гадес хаан тэдний цаашдын хувь заяаг шийднэ. Нүгэлтнүүдийг могой болон бусад аймшигт чөтгөрүүдээр тарчлаадаг. Амьтдаа хууль ёс зөрчсөн хүн сүм дуганд ямар нэг амьтны цусаар шүтээн бурханд өргөл тахил өргөж, шүтлэгт булаг усны рашаан хэрэглэн шашны зан үйл гүйцэтгэн нүглээ наминчилж болно. Одиссейн домогт шударга бус үйлдлийнхээ төлөө тарчилж буй Тантал, Сизиф нарын тухай өгүүлдэг.

Грекчүүд бурхадад зориулан шүтээн, сүм дуган босгоно. Төрөл угсаа бүхэн өөр өөрийн шүтээн бурхантай. Жишээ нь Этеобутадуудын төрлийнхөн Посейдоныг шүтнэ. Аркадий, Коринф, Киренд Деметраг, Аттикт газар тариалан, гэрийн тэжээмэл амьтан, ёс суртахуун, эмх журамын бурхан Аполлоныг, Афинд усан үзмийн бурхан Дионисыг шүтнэ. Ураг төрөл бүхэн өөрийн хаадыг шүтээн бурхантайгаа зүйрлэн орлуулдаг байв. Баяр ёслолын үеэр бурхадыг дүрсэлсэн цом болон мөнгө бэлэглэдэг байжээ. Дионис бурханд зориулсан баяр ёслолд боолчуудыг ч оролцохыг зөвшөөрдөг байсан ба шинэ усан үзмийн дарсаар шагнадаг байжээ.

Эртний Грекийн хот улс үүссэн баатарлаг үед бурхадыг хүчтэй, чадалтайгаар төсөөлөхөөсөө илүү ухаалаг, заль мэхтэй, уран аргатайгаар тодорхойлох хандлагатай болсон юм. Энэ үеэс грекчүүд бурхадыг үл тоомсорлох, онцгой ач холбогдолгүйгээр хандах өнгө аястай болжээ.

¹ История Древнего мира. Древняя Греция. Минск Харвест. 1998. стр.157-160